

**ХҮМҮҮНЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн П.Анужин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан нараас 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан танилцуулж, Байнгын хорооны гишүүд төсөлтэй холбоотой асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням олон улсын туршлагаас үзэхэд энэ хуультай ижил утгатай хууль боловсролын салбарт байдаг эсэх, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Боловсролын тухай хуульд хуулийн төсөлд тусгасан агуулгатай ижил зүйл, заалт байдаг эсэх, багшийн ажлын ачааллыг бууруулж, олон улсын жишигт хүрэхүйц үндэсний боловсролын тогтолцоо, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг уг хуулийг хэрэгжүүлэх арга зам, агуулга талаас нь хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа зөв хүн бий болгох, хүний хөгжил, хүн хүнээ хайрлах, хүнлэг сэтгэлтэй байх гэх мэт хүүхдийн төлөвшилд анхаарах ёстой чухал зүйлүүд нь боловсролын багц хуульд тусгагдсан байдаг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан энэ хуулийн төслийг боловсролын багц хуулийн төсөлд тусгаж, тусад нь бүлэг зүйл, заалт нэмж оруулах саналтай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг хуулийн төсөлд тусгагдсан заалтууд боловсролын салбарт мөрдөгдөж байгаа иргэний ёс зүйн хичээлийн хөтөлбөрт бүгд багтсан байдаг ба эдгээр хөтөлбөртэй ижил агуулгатай сэдвүүдийг бие даасан хууль болгохыг дэмжихгүй байгаа талаар тус тус санал хэллээ.


Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71.4 хувь нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг
хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.МӨНХБАТ